

Олон Улсын Валютын Сангийн Дүрмийн дөрөвдүгээр заалтын дагуу хийгдсэн 2011 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг, хөтөлбөрийн дараах хяналт үнэлгээ, хөтөлбөрийн дараах хөндлөнгийн хяналт үнэлгээний тайлангуудыг Захирлуудын зөвлөл хэлэлцэж баталлаа

Олон нийтэд зориулсан мэдэгдэл (PIN) № 11/39
2011 оны 3 дугаар сарын 23

Олон нийтэд зориулсан мэдэгдэл нь ОУВС-гийн байр суурь, эдийн засагт гарч буй өөрчлөлт хөгжилт, бодлогод хийсэн дүн шинжилгээг ил тод болгохтой холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Дүрмийн дөрөвдүгээр заалтын дагуу гишүүн оронтой хийдэг зөвлөлдөх хэлэлцүүлэг, бүс нутгийн хэмжээнд гарч байгаа өөрчлөлт хөгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, хөтөлбөрийн дараах үнэлгээ, урт хугацааны хөтөлбөртэй байгаа улсуудын хувьд хөтөлбөрийн дараах хөндлөнгийн хяналт үнэлгээний үр дүнг Захирлуудын зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэний дараагаар тухайн улс буюу улс орнуудын зөвшөөрөлтэйгээр энэхүү мэдэгдлийг гаргадаг. Мөн түүнчлэн, Захирлуудын зөвлөл дээр хийгдсэн бодлогын ерөнхий асуудлуудын талаарх хэлэлцүүлгийн үр дүнг ийнхүү олон нийтэд танилцуулдаг бөгөөд зарим тохиолдолд асуудлын агуулгаас хамаараад Захирлуудын зөвлөл олон нийтэд мэдээлэл хүргэх шаардлагагүй гэж үзэж болно.

Олон Улсын Валютын Сангийн Захирлуудын зөвлөл 2011 оны 3 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, Дүрмийн дөрөвдүгээр заалтын дагуу хийгдсэн 2011 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг, хөтөлбөрийн дараах хяналт үнэлгээ, хөтөлбөрийн дараах хөндлөнгийн хяналт үнэлгээний тайлангуудыг хэлэлцэж баталлаа.¹

Нөхцөл байдал

Монгол Улсын эдийн засаг эрдэс баялгийн экспортоос ихээхэн хамааралтай, өнгөрсөн хугацаанд макро эдийн засгийн бодлого нь мөчлөг дагасан шинжтэй байж ирсний улмаас дэлхийн санхүү эдийн засгийн

¹ ОУВС-гийн Дүрмийн дөрөвдүгээр заалтын дагуу ОУВС нь гишүүн улс орнуудтай хоёр талт хэлэлцүүлэг хийдэг бөгөөд энэ нь ихэвчлэн жил бүр хийгддэг. ОУВС-гийн тухайн улсыг хариуцсан ажлын хэсэг гишүүн оронд очиж, эдийн засаг, санхүүгийн мэдээлэл цуглуулан, төр засгийн хүмүүстэй эдийн засагт гарсан өөрчлөлт хөгжилт, бодлогын асуудлуудыг авч хэлэлцдэг. Үүний дараагаар хэлэлцүүлгийн дүнг нэгтгэсэн тайланг бэлтгэж, Захирлуудын зөвлөлд танилцуулдаг. Захирлуудын зөвлөлийн хурлаас зөвлөлдөх хэлэлцүүлгийн дүнг баталсны дараа Захирлуудын зөвлөлийн даргын хувьд ОУВС-гийн Гүйцэтгэх захирал зөвлөлийн гишүүдийн байр суурийг нэгтгэн танилцуулж, улмаар гишүүн орны төр засгийн байгууллагад уламжилдаг.

хямралд хүчтэй өртсөн. 2009 оны эхээр төв банкны гадаад валютын нөөц багасч, улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэргүй болж, инфляци хоёр оронтой тоонд хүрч, банкны салбар хүндрэлд орсноор эдийн засаг сүйрлийн ирмэгт тулж ирсэн. 2009 оны 4 дүгээр сарын 1-нд 18 сарын хугацаатай Стэндбай хөтөлбөр батлагдсан бөгөөд төр засгийн зүгээс бодлогын арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэн, хандивлагчдын хамтын нийгэмлэгээс санхүүгийн дэмжлэг авч, дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ сэргэсний үр дүнд эдийн засаг богино хугацаанд тогтворжиж чадсан. Эдийн засгийн өсөлт 2010 онд сайн сэргэж, 6 хувьд хүрсэн. Өвөлжилт хүндэрч хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл огцом багассан хэдий ч ийм хэмжээний сэргэлт гарсан нь үнэхээр гайхалтай. Гэвч хүнсний барааны нийлүүлэлтэнд үүссэн цочролын улмаас 2010 оны ихэнх хугацаанд инфляци хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн бөгөөд үүнд махны үнэ өссөн нь голлох үүрэг гүйцэтгэлээ. Зэсийн үнэ нэмэгдэж, нүүрсний үйлдвэрлэл хурдацтай өссөн нь экспортын өндөр өсөлтийг бий болгож, гадаад валютын нөөцийг түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүргэхэд нөлөөлөв.

Эдийн засгийн өсөлт 2011 онд өндөр хэвээр байж, 10 орчим хувьд хүрч нэмэгдэхээр байна. Харин улсын нэгдсэн төсвийн зарлагыг их хэмжээгээр өсгөж, төлөвлөгөө ёсоор хэрэгжүүлэх гэж байгаа нь зах зээл дээр илүүдэл эрэлтийг бий болгож, улмаар инфляцийг хөөрөгдөн, импортыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Уул уурхайн томоохон хоёр төслийн үйлдвэрлэл 2013 оноос эхлэхтэй зэрэгцээд эдийн засгийн өсөлтийн төлөв тааламжтай хэвээр байж, үйлдвэрлэлийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болно.

Захирлуудын зөвлөлийн хурлаар 2009 оны 4 дүгээр сард батлагдсан санхүүжилтийн онцгой нөхцөлтэй Монгол Улсын Стэндбай хөтөлбөрийн хэрэгжилтэнд ОУВС-гийн дотоод журмын дагуу хийгдсэн хөндлөнгийн хяналт үнэлгээний тайланг мөн авч хэлэлцсэн. Монгол Улсын энэхүү хөтөлбөр нь Азийн санхүүгийн хямралаас хойш ОУВС-гаас Азид хэрэгжүүлсэн хамгийн анхны хөтөлбөр байсан юм. Хөтөлбөрийн дараах хөндлөнгийн үнэлгээ нь хөтөлбөрийн бүтэц агуулга, хэрэгжилтээс гадна хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд олж авсан гол сургамжуудад анхаарлаа хандуулсан. Уг үнэлгээний тайланд дурьдсанаар дэлхийн санхүү эдийн засгийн хямралтай зэрэгцээд Монгол Улсын макро эдийн засгийн байдал богино хугацаанд хүндэрсэн бөгөөд үүнийг тогтворжуулах, мөн бодлогын хүрээг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байсан бүтцийн шинэчлэл хийхэд хөтөлбөр дэмжлэг болж чадсан. Хөтөлбөрийн хэрэгжилтээс авсан сургамжууд гэвэл том хэмжээний санхүүжилтийн хөтөлбөрийг нөхцөл байдалд нь сайн тохирсон нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх нь хямралыг тогтворжуулахад үр дүнтэй байж чадна; цагаа олсон техник туслалцаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд маш сайн дэмжлэг болж чадна; хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараагаар шинэчлэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх баттай үүрэг амлалтыг олж авах нь цаашид анхаарах асуудал хэвээр байна.

Захирлуудын зөвлөлийн үнэлгээ

ОУВС-гийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараагаар эдийн засгийн өсөлт сэргэснийг Захирлуудын зөвлөлийн гишүүд нааштайгаар хүлээж авлаа. Гэвч ихээхэн хүчин чармайлтаар бий болгосон макро эдийн засгийн тогтвортой байдлыг мөчлөг дагасан бодлого алдагдуулж, эдийн засагт хэт халалт үүсч болзошгүй гэсэн бодлогын гол сорилт үүсч байна хэмээн гишүүд үзэж байна. Иймд төсвийн зарлагыг хязгаарлаж, зах зээл дээрх эх үүсвэрийн хэмжээг багасгах шаардлагатай байна. Цаашдын байдлыг ажиглавал дунд хугацааны төлөв тааламжтай боловч Монгол Улсын ашигт малтмалын арвин их нөөц баялгийг зөв зохистой ашиглах нь тогтвортой өсөлт, урт удаан хугацаанд хадгалагдах хөгжилт цэцэглэлтэнд зайлшгүй ач холбогдолтой гэж Захирлын зөвлөлийн гишүүд үзлээ.

Төсвийн зарлагыг энэ онд үлэмж хэмжээгээр өсгөж төлөвлөсөн нь инфляцийг хөөрөгдөж, эмзэг ядуу бүлгийнхэнд сөргөөр нөлөөлөх асуудлыг анхаарах ёстой гэж гишүүд үзлээ. Иймд 2011 оны төсөвт тодотгол хийж, төсвийн зарлагыг бууруулан, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасан мөчлөгийн шалгуур, дунд хугацааны зорилтуудыг хангах нь зүйтэй гэж үзлээ. Мөн түүнчлэн зорилтот бүлэгт чиглүүлсэн нийгмийн халамжийн тогтолцоог бүрдүүлэх нь ойрын хугацааны тэргүүлэх чиглэлийн зорилт байх ёстой хэмээн гишүүд тодорхойллоо. Төсвөөс гадуур өр төлбөр үүсгэж болзошгүй учраас хөгжлийн банк байгуулах, засгийн газрын баталгаа гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх асуудалд болгоомжтой хандахыг анхааруулав.

Инфляцийн хөөрөгдлийг тогтоон барих үүднээс мөнгөний бодлогын хүрээнд илүү урьдач арга хэмжээ авах бололцоо байгааг гишүүд олж харсан бөгөөд эхний ээлжинд бодлогын хүүг нэн даруй өсгөх нь зүйтэй гэж үзлээ. Түүнээс гадна инфляцид илэрхий анхаарах байдлыг нэмэгдүүлсэн мөнгөний бодлогын хүрээ рүү дунд хугацаанд шилжихийг үндсэндээ дэмжсэн. Цаашилбал, эх үүсвэрийн удирдлагыг боловсронгуй болгож, тус улсад орж ирж байгаа хөрөнгийн урсгалыг шингээж авах чадавхийг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Уян хатан ханшийн тогтолцоо сайн ажиллаж байна хэмээн Захирлуудын зөвлөлийн гишүүд үзлээ. Төр засгийн зүгээс төгрөгийн ханшийг зах зээлийн жамаар тогтох нөхцөл бололцоог хангахын төлөө байгааг нааштай хүлээн авч, гадаад зах зээлээс орж ирэх цочрол, эдийн засагт явагдаж байгаа бүтцийн суурь өөрчлөлтийн эсрэг жийрэг болох ач тусыг нь онцолсон. Одоогоор валютын ханш олон янзаар тогтоогдох явдал байсаар байгаа бөгөөд нөхцөл байдал бүрэлдсэн даруйд үүнийг халах тал дээр төр засгийн зүгээс ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Санхүүгийн салбарт тавих хяналтыг бэхжүүлэх, Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөрийн хүрээнд гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг Захирлуудын зөвлөлийн гишүүд үнэллээ. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам зааврыг хатуу чанд мөрдүүлэхийн ач холбогдлыг онцлоод, банкны бүтцийн өөрчлөлт, дахин хөрөнгөжүүлэлтэнд зориулан төсвийн дэмжлэг олгох асуудлыг зохицуулсан хуулийг баталж гаргана гэдэгт итгэж байгаагаа илэрхийлэв. Түүнээс гадна

хадгаламжийн даатгалын тогтоолцоог ойрын ирээдүйд бий болгож, банкин дахь мөнгөн хадгаламжинд засгийн газраас гаргасан баталгааг хүчингүй болгохыг хөхүүлэн дэмжив.

Хөтөлбөрийн дараах хөндлөнгийн үнэлгээний тайлангийн гол дүгнэлтүүдтэй Захирлуудын зөвлөл санал нийлэв. Стэндбай хөтөлбөрийн тусламжтайгаар бодлогын томоохон өөрчлөлт хийж, ОУВС-гийн санхүүжилтийн ихэнх хэсгийг хөтөлбөрийн эхний үед авч ашиглан, бусад хандивлагчдын тусламж дэмжлэгийг төвлөрүүлснээр гадаад цочролын үр нөлөөг багасгаж чадсан. Эдийн засгийн бодлогын хүрээнд суурь өөрчлөлт гаргах чиглэлээр мөн тодорхой үр дүнд хүрсэн. Цаашид Монгол Улсын эдийн засгийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэхийн тулд хөтөлбөрийн хүрээнд эхлүүлсэн шинэчлэлийн арга хэмжээг эцсийн үр дүнд хүргэхийн тулд хүчин чармайлтаа үргэлжлүүлэн гаргахыг Захирлуудын зөвлөлөөс уриалав. Монгол Улсын төр засгийн зүгээс хөтөлбөрийн дараах хяналт үнэлгээний хүрээнд ОУВС-тай явуулж буй нягт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байгааг сайшаав.

Монгол Улс: Эдийн засаг, санхүүгийн зарим үзүүлэлтүүд, 2009–2012

	ХБГ		Төсөөлөл	
	2009	2010	2011	2012
Бодит салбар	(Өөрчлөлт, хувиар)			
ДНБ-ий бодит өсөлт	-1.3	6.1	10.3	7.6
Эрдэс баялгийн	2.3	9	13.4	12.6
Эрдэс баялгийн бус	-2.6	5	9	5.5
Хэрэглээний үнэ (хугацааны дундаж)	6.3	10.2	16.4	16
Хэрэглээний үнэ (хугацааны эцэст)	1.9	14.3	20	12
ДНБ-ий дефлятор	1.8	18	14.1	8.9
Улсын нэгдсэн төсөв	(ДНБ-д эзлэх хувиар)			
Нийт орлого, тусламжийн дүн	30.2	37.2	35.1	35
Нийт зарлага, цэвэр зээл	35.2	36	38.5	38.9
Урсгал тэнцэл	2.6	9.4	4.4	6.8
Суурь тэнцэл	-4.5	1.7	-3.1	-3.7
Нийт тэнцэл (тусламжийн дүн ороод)	-5	1.2	-3.5	-3.9
Эрдэсийн бус нийт тэнцэл	-11.8	-10.6	-13.3	-11.8
Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцэл 1/	-6.8	-2.8	-6.3	-6.5
Мөнгө зээл	(Өөрчлөлт, хувиар)			
Нийт мөнгө	26.9	61.6	45	23.5
Нийт мөнгөний хурдац (ДНБ/Нийт мөнгө)	2.3	1.8	1.5	1.5
ТБ-ны 7 хоногийн ҮЦ-ны хүү, хугацааны эцэст (хувиар)	10	11
Төлбөрийн тэнцэл	(Сая ам. доллар)			
Урсгал дансны тэнцэл (албан ёсны шилжүүлэг ороод)	-410	-931	-1,302	-1,438
(ДНБ-д эзлэх хувиар)	-9	-15.2	-15.1	-13.6
(ДНБ-д эзлэх хувиар, уул уурхайн импортыг хасаад)	-5.8	-5.8	2.5	0.1
Гадаад худалдааны тэнцэл	-194	-278	-1,049	-1,107
Экспорт	1,876	2,899	3,825	4,083
Импорт	-2,070	-3,177	-4,874	-5,190
Гадаадын хөрөнгө оруулалт	496	1,574	1,130	548
Гадаад валютын нийт албан нөөц (хугацааны эцэст)	1,328	2,290	3,586	4,127
(дараа оны бараа үйлчилгээний импортын сараар)	4.1	4.9	7.1	8.8
Гадаад худалдааны үнэ				
Экспортын үнэ (ам. доллар; өөрчлөлт, хувиар)	-18.2	29	9.8	-1.4
Импортын үнэ (ам. доллар, өөрчлөлт хувиар)	-18	13.2	7.4	0.5
Гадаад худалдааны нөхцөл (өөрчлөлт, хувиар)	-0.2	14	2.3	-1.9
Засгийн газрын болон Засгийн газрын баталгаатай өр	(ДНБ-д эзлэх хувиар)			
Улсын нийт өр	46.6	43	38.6	37.1
Дотоод өр 2/	3.4	12.2	15.8	17.3
Гадаад өр	43.3	30.8	22.8	19.8
(сая ам. доллар)	1,977	2,023	2,064	2,097
Төгрөгийн ханш				
Ам. доллартай харьцах (хугацааны эцэст)	1,443	1,259
Ам. доллартай харьцах (хугацааны дундаж)	1,441	1,348
Үйлчилж буй нэрлэсэн ханш (хугацааны эцэст; өөрчлөлт, хувиар)	-15.8	3.4
Үйлчилж буй бодит ханш (хугацааны эцэст; өөрчлөлт, хувиар)	-11.1	11.3
ДНБ, оны үнээр (тэрбум төгрөг)	6,591	8,255	10,382	12,166

Эх сурвалж: Монгол Улсын эрх бүхий байгууллагууд; ОУВС-гийн мэргэжилтнүүдийн тооцоо төсөөлөл.

1/ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд тодорхойлсноор, төсвийн орлогыг тооцохдоо бодит үнийн оронд тэнцвэржүүлсэн үнийг ашигладаг.

2/ 2009 оны дотоод өрөнд Оюутолгойгоос авсан татварын урьдчилгааг оруулсан, харин 2010 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2011 оны төсөөлөлд банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд гарч болзошгүй төсвийн санхүүжилт, Оюутолгойн хувь эзэмшил дэх засгийн газрын хувийг санхүүжүүлэх зардлыг нэмж тооцсон.

